



**ХАЛДВАРТ ӨВЧИН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

┌ Журам батлах тухай ┐


Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.4, 16.16 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.3 дахь заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.2, 8 дугаар зүйл 8.1 дэх заалт, Төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 6330:2017, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн “Амбулаторийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам”- ыг нэгдүгээр, “Өдрийн эмчилгээний журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй нийт эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнд танилцуулахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд захирал (Ц.Чинбаяр)-д, хэрэгжүүлэн ажиллахыг нийт алба тасгийн дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанарын албаны дарга (Б.Батсүх)-д үүрэг болгосугай

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ц. Билэгтсайхан

Ц.БИЛЭГТСАЙХАН

ХӨСҮТ			Боловсруулсан огноо	2023.03.15
			Баталсан огноо	
			Хуудасны тоо	7
Тушаалын дугаар	A/	БАТАЛСАН	Ерөнхий захирал Ц.Билэгтсайхан	
Мөрдөж эхлэх огноо	2023.03.15			

АМБУЛАТОРИЙН ТУСЛАМЖ , ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЖУРАМ

Баримт бичгийн төлөв	Боловсруулсан	Хянасан		Хянасан огноо
	Чанарын менежер	Чанарын албаны дарга	Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд захирал	
	О.Эрдэнэболор 2023.03.06	Б.Батсүх	Ц.Чинбаяр	


ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

“Бүртгэл хяналтын журам”-ыг жилд 1-ээс доошгүй удаа хянана. Журамд тусгах шаардлагатай өөрчлөлтийг хэлэлцэж удирдах албан тушаалтнаар баталгаажуулна.

Журамд оруулсан өөрчлөлтийг доорх “Өөрчлөлтийн бүртгэл”-д тэмдэглэнэ.

Өөрчлөлт оруулсан бүлэг/зүйл	Өөрчлөлтийн товч утга	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр

ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын
2023 оны 04 дүгээр сарын 07 ны өдрийн
№156 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



АМБУЛАТОРИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Тус төвийн амбулаторийн тасгаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчид эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй, чанартай үзүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. Уг журам нь ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцооны стандартын шаардлагад нийцсэн болно.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Тус төвийн хэмжээнд үйлчилж, амбулаторийн тасгийн үйл ажиллагаанд хамаарна.

ГУРАВ. ҮЙЛ ЯВЦ

3.1 Үйлчлүүлэгчийг хөтөч сувилагч угтан авч, эрт сэрэмжлүүлэх үнэлгээ хийнэ. Эрт сэрэмжлүүлэх оноо ≤ 4 бол дугаар авч, цахим бүртгэлээс эмчид үзүүлэх товлолт цаг авна.

3.2 Цахим бүртгэлийн ажилтан үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн даатгал төлөлтийг шалгаж, даатгалтай бүрэн хийгдсэн тохиолдолд шууд цаг олголтыг хийнэ. Хэрэв даатгал бүрэн бус, хийгдээгүй тохиолдолд эрүүл мэндийн даатгалыг төлүүлэн цахим бүртгэлд бүртгэнэ.

3.3 Эрт сэрэмжлүүлэх оноо ≥ 4 бол угтах үйлчилгээний ажилтан шууд эмчид үзүүлж асуудлыг шийдвэрлүүлнэ.

3.4 Амбулаторийн эмч үзлэг, оношилгоог Эрүүл мэндийн сайдын баталсан эмнэлзүйн зааврууд болон ЭМДҮЗ-ийн 01,03,12 дугаар тогтоолын шалгуурын дагуу хийнэ.

3.5 Эмч үзлэгийн дүгнэлт гарган зөвлөгөө өгч буцаах, хэвтүүлэн эмчлэх, өдрийн эмчилгээнд эмчлүүлэх асуудлуудыг шийдвэрлэнэ.

ДӨРӨВ. ЦАГИЙН ХУВААРЬ

4.1 Ажлын өдрүүдэд 08:30-16:00, Цайны цаг 12:00-12:30 байна. Жич: Үзлэгийн эмч жижүүрт хоносон үед маргааш өдрийн 11:30 цагаас жижүүрийн амралт авна.

ТАВ. ЦАГ ОЛГОХ, ЦАГ ЦУЦЛАХ, ХАРИУ ОЛГОХ

5.2 Цаг олгох:

5.2.1 Ажлын цагаар ард иргэдээс 11453849, 1800-0119 дугаарт болон биечлэн ирсэн үед эмнэлгээр үйлчлүүлэх үзлэгийн цаг олгоно.

5.3 ЦАГ ЦУЦЛАХ

5.3.1 Үйлчлүүлэгч үзлэг товлөгдсөн хугацаанаас 30 минутын өмнө өөрийн биеэр ирэн үзлэгийн цагаа баталгаажуулна. Цаг баталгаажуулаагүй тохиолдолд тухайн цагийг цуцлан, дараагийн үйлчлүүлэгчид цагийг олгоно

5.4 ХАРИУ ОЛГОХ

5.4.1 Шинжилгээний хариуг биечлэн болон цахим шуудангаар олгоно.

ЗУРГАА.ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ

6.1 Үйлчлүүлэгч өөрийнхөө болон гэр бүлийнхээ эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх үүрэгтэй

6.2 Эрүүл мэндийн байгууллагын ажилтантай хүндэтгэлтэй харилцаж, соёлтой үйлчлүүлэх үүрэгтэй.

6.3 Байгууллагын дотоод дүрэм, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.

6.4 Эмчилгээ үйлчилгээний заавар дэглэмийг чанд сахих үүрэгтэй.

6.5 Бусдын эрхийг хүндэтгэх үүрэгтэй.

6.6 Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байхад зураг авах болон дуу, дүрс бичлэг хийхгүй байх үүрэгтэй.

6.7 Өөрийн болон асран хамгаалж буй үйлчлүүлэгчийн биеийн байдал, эрүүл мэндийн талаарх мэдээллийг эмнэлгийн мэргэжилтэнд үнэн зөв, бүрэн мэдээлэх үүрэгтэй.

ДОЛОО. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ

7.1 Үйлчлүүлэгч нь эрүүл мэндийн чанартай, тэгш хүртээмжтэй тусламж, үйлчилгээг авах эрхтэй

7.2 Биеийн эрүүл мэндийн байдал болон эмчилгээ, үйлчилгээний үр дүн, өвчний явц, цаашид хийх эмчилгээ, гарч болох үр дагаврын талаар мэдээлэл авч, эмнэлгийн мэргэжилтэнтэй харилцан ярилцах, тайлбар авах эрхтэй

7.3 Өөрийн эрүүл мэндийн талаарх нууцаа хамгаалуулах эрхтэй.

7.4 Эмчээ сонгон эмчлүүлэх, тусламж үйлчилгээний явцад эмчлэгч эмчээ солих санал тавих эрхтэй.

НАЙМ. ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ


8.1 Амбулаторийн тасгийн эрхлэгч, үзлэгийн эмч, резидент эмч, сувилагч, холбогдох бусад мэргэжилтнүүд энэ журмыг мөрдөж ажиллана.

8.2 Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд захирал, Чанарын албаны дарга, менежер, тасгийн эрхлэгч нар энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

ЕС. ЖУРАМ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Журам зөрчигчдөд хөдөлмөрийн тухай хууль, тус төвийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу холбогдох хариуцлага тооцно.





ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

НЭГ. ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧДИЙН МӨРДӨХ НИЙТЛЭГ ЖУРАМ:

1. Дараах шаардлагыг үндэслэн өдрийн эмчилгээнд хамруулна.
 - 1.1 Өдрөөр хийгдэх эмчилгээ үйлчилгээний дараа ажиглалтын хугацаа дуусахад үйлчлүүлэгч эргэн харих бүрэн чадамжтай.
 - 1.2 Бага насны хүүхэд, өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй иргэд эмчилгээний явцад байнгын асран халамжлагчтай байх тохиолдол
 - 1.3 Үйлчлүүлэгч нь хэвтрийн дэглэм сахих заалтгүй байх тохиолдол
 - 1.4 Үйлчлүүлэгч 24 цагийн дотор эмнэлэгт давтан үзүүлэх шаардлагагүй тохиолдол
 - 1.5 24 цагийн туршид мэргэжлийн сувилахуйн тусламж, үйлчилгээ авах шаардлагагүй тохиолдол
 - 1.6 Тухайн үйлчлүүлэгчийн өдрийн эмчилгээний ор хоног нь 5-7 хоног байна.
 - 1.7 Эмнэлэгт хэвтэхдээ тухайн оношийг баталгаажуулах шинжилгээг хийнэ
 - 1.8 Тус тасагт хэвтэн эмчлүүлэгчид өдөр бүр 8:30-15:30 цагийн хооронд цахимаас олгосон цагт ирж эмчилгээг хийлгэнэ.

ХОЁР. ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСАГТ ХЭВТҮҮЛЭХ ӨВЧНИЙ ЖАГСААЛТ

Өдрийн эмчилгээнд өвчтөний эмчлүүлэх онош нь ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолд заагдсан оношийн хамааралтай бүлэгт багтсан байна. Үүнд:

- 2.1 A00-B99
- 2.2 E08-E13
- 2.3 I10-I19
- 2.4 J11-J99
- 2.5 K70-K77
- 2.6 K80-87

ГУРАВ. ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭНД ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 12 ДУГААР ТОГТООЛЫН ДАГУУ ХАМРАГДАХГҮЙ ӨВЧНИЙ ЗААЛТ:

- 3.1 Элэгний хатуурал, ээнэгшлийн бус шат Чайльд-Пью С ангилал
- 3.2 Дотрын өвчний хавсарсан хэлбэрүүд
 - Зүрх судас, амьсгалын дутагдалтай өвчтөн ;
 - Уушгины хүнд хэлбэрийн эмгэг ;
 - Даралт ихсэх өвчин 3 дугаар зэрэг ;

- Цөсний болон бөөрний чулууны хатгалт ;
- Чихрийн шижингийн ээнэгшил алдагдсан хэлбэр;

3.3 Цусархаг хам шинжтэй тромбоцит $100 \times 10^9/l$ -ээс бага өвчтөн. Эмчилгээний хоолны дэглэм онцгой шаардлагатай.

3.4 Эмчийн жороор эмийг гэрээ уух боломжтой, өвчтөний биеийн байдал хөнгөн бол хамрагдахгүй.

ДӨРӨВ. ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭНЭЭС БУСАД ТОХИРОХ ХЭЛБЭРИЙГ СОНГОХ ТОХИОЛДОЛ

Дараах тохиолдолд өдрийн эмчилгээ, үйлчилгээнд хамааруулахгүйгээр тусламж, үйлчилгээний бусад тохирох хэлбэрийг сонгон үйлчилнэ.

Үүнд:

4.1 Эмчийн хяналтад 24 цаг байх шаардлагатай үед ;

4.2 Эмчилгээ, үйлчилгээг өдөрт нэгээс олон удаа давтан эмчилгээ хийх, цагийн тариа хийлгэх шаардлагатай үед;

4.3 Хэвтрийн дэглэм сахих шаардлагатай өвчтөний биеийн байдал хүнд өвчний явц хүндрэх тохиолдолд;

4.4 Шөнийн цагаар дахидаг, хурц өвдөлт өгдөг өвчний үед;